



БАТЛАВ:

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
 МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД
 АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА

Ө.Энхтүвшин Ө.ЭНХТҮВШИН

2018 оны 10 дугаар сарын 05-ний өдөр

**УЛААНБААТАР ХОТЫН ОЛОН УЛСЫН ШИНЭ НИСЭХ БУУДЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХАД
 ЗАСГИЙН ГАЗРААС ТОМИЛОГДСОН АЖЛЫН ХЭСГИЙН ТҮВШИНД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх ажил	Эхлэх дуусах хугацаа	Тулгараад байгаа асуудлууд	Хэрэгжүүлэх харьяалал		Хүрэх түвшин, үр дүн
				Байгууллага	Хариуцах эрх бүхий албан тушаалтан	
Нэг. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хүрээнд:						
1.1	Аэродромын засвар үйлчилгээний барилга <i>Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга/</i>	10/01-11/30	Гэрээ нь анх 2016 онд байгуулагдсан, өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. Гэрээний сүүлийн сунгалтад 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр хүлээлгэн өгөхөөр тусгагдсан. Гүйцэтгэгч тал болон валютын ханшийн зөрүүний өсөлтөөс шалтгаалан зардал хэтэрсэн. Гэрээ дүгнэх, сунгах ажил хийгдээгүй байгаа. <i>/Төсөвт өртөг 5.1 тэрбум үлдэгдэл 423 сая төгрөг/ Ашиглалтад орох хугацаа хэтэрсэн. Ажлын гүйцэтгэл 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 88.4 хувьтай байна. Нэмэлт зардлыг ИНЕГ-ын төсөвт суулгахаар Сангийн яамнаас шийдвэрлэсэн. /Нэмэлт зардлын асуудлыг дахин нягтлах/</i>	Сангийн яам, ЗТХЯ, БХБЯ, Барилгын хөгжлийн төв, ИНЕГ,	Барилга хот байгуулалтын сайд Х.Баделхан ЗТХ-ийн Дэд сайд Л.Халтар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт ЗТХЯ-ны Агаарын тээврийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн ИНЕГ-ын дарга Л.Бямбасүрэн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Н.Энхбат	Барилгын ажлыг яаралтай дуусгаж, улсын комиссыг ажиллуулан ашиглалтад хүлээлгэн өгөх Гүйцэтгэлд хяналт тавин, хариуцаж байгаа байгууллагуудын хариуцлагыг өндөржүүлэх, санаачилгатай ажиллуулах

1.2	Ачаа шуудан үйлчилгээний барилга <i>/Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга/</i>	10/01-11/30	Гэрээ нь анх 2016 онд байгуулагдсан, өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. Гэрээний сүүлийн сунгалтад 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр хүлээлгэн өгөхөөр тусгагдсан. Гүйцэтгэгч тал болон валютын ханшийн зөрүүний өсөлтөөс шалтгаалан зардал хэтэрсэн. Гэрээ дүгнэх, сунгах ажил хийгдээгүй байгаа. /Төсөвт өртөг 4.4 тэрбум үлдэгдэл 524 сая төг/ Ашиглалтад орох хугацаа хэтэрсэн. Ажлын гүйцэтгэл 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 89.4 хувьтай байна. Нэмэлт зардлын асуудлыг ИНЕГ-ын 2019 оны төсөвт суулгахаар Сангийн яамнаас шийдвэрлэсэн. <i>/Нэмэлт зардлыг дахин нягтлах шаардлагатай/</i>	Сангийн яам ЗТХЯ БХБЯ Барилгын хөгжлийн төв МХЕГ	Барилга хот байгуулалтын сайд Х.Баделхан ЗТХ-ийн Дэд сайд Л.Халтар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт ЗТХЯ-ны агаарын тээврийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн ИНЕГ-ын дарга Л.Бямбасүрэн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Н.Энхбат	Гэрээ сунгагдаж ашиглалтад хүлээлгэн өгөх хугацаа тодорхой болно. Барилгын ажлыг яаралтай дуусгаж, улсын комиссыг ажиллуулан ашиглалтад хүлээлгэн өгөх; Гүйцэтгэлд хяналт тавин, хариуцаж байгаа байгууллагуудын хариуцлагыг өндөржүүлэх, санаачилгатай ажиллуулах
1.3	Катерингийн барилгын концессийн гэрээг байгуулах <i>/Зорчигчдын хоолыг бэлтгэх үйлчилгээний барилга концесс эзэмшигчийн хөрөнгөөр баригдана/</i>	10/01-12/01	Засгийн газрын шийдвэрийн дагуу Үндэсний хөгжлийн газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/135 дугаар тушаалаар "Зорчигчдын хоол бэлтгэх зориулалт бүхий Катерингийн барилгыг барьж, үйлчилгээ үзүүлэх төсөл"-ийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг хоёр үе шаттайгаар 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зарласан. Төслийн урьдчилсан шалгаруулалтад 8 хуулийн этгээд оролцохоор хүсэлтээ илэрхийлснээс 5 хуулийн этгээд саналаа ирүүлж, нэг хуулийн этгээд тэнцсэн. Шалгаруулалтад тэнцсэн хуулийн этгээдийг Засгийн Газрын хуралдаанд танилцуулахаар хүлээгдэж байна. Энэ нь Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах хугацаанд нөлөөлөх хандлагатай байна.	Үндэсний хөгжлийн газар ИНЕГ	ЗТХЯ-ны Агаарын тээврийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан ИНЕГ-ын дарга Л.Бямбасүрэн	Шалгаруулалтад тэнцсэн хуулийн этгээдийг засгийн газрын хуралдаанд танилцуулан холбогдогдох шийдвэрийг гаргуулсан байна. Концессийн гэрээг байгуулсан байна.
1.4	Катерингийн барилгын ажлыг	2018/11/30-2019/05/30	Зорчигчдын хоолыг бэлтгэх үйлчилгээний барилгыг концессийн гэрээний дагуу			Зорчигчдын хоолыг бэлтгэх үйлчилгээний

	эхлүүлэх, ашиглалтанд хүлээн авах		бэлтгэл ажлыг хангаж барилгын ажлыг эхлүүлэх.		ЗТХЯ-ны Агаарын тээврийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн ИНЕГ-ын дарга Л.Бямбасүрэн АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн	барилгыг концессийн гэрээний дагуу концесс эзэмшигчийн хөрөнгөөр барилгыг бариулж ашиглалтанд оруулсан байна.
1.5	Үндсэн зээлийн хүрээнд ашиглалтад хүлээлгэн өгөх ёстой "Шатахуун хангамж"-ийн байгууламжийг хүлээн авах	10/01-12/15	Шатахууны байгууламж дээр бүртгэгдсэн зөрчлүүдийг арилгуулах болон шатахуун буулгах гарны техникийн үзүүлэлтийг өөрчлүүлэх асуудлыг шийдвэрлэх, хүлээн авах хуваарийг гүйцэтгэгч компаниар баталгаажуулах	ЗТХЯ ИНЕГ ТХН	ЗТХЯ-ны Агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Мягмарсүрэн АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Н.Энхбат	Шатахууны байгууламжийг хүлээн авч бүрэн хүчин чадлаараа ажиллах нөхцлийг бүрдүүлэх, гэрчилгээжүүлэх ажлыг эхлүүлсэн байна. Оператор компанид хүлээлгэн өгөх бэлтгэл ажлыг хангах
1.6	Газрын үйлчилгээний тусгай зориулалтын 6 ширхэг авто машины асуудлыг шийдвэрлэх	10/01-11/15	Мөстөлтийн эсрэг шингэн цацах авто машин болон зурвасны үрэлтийн коэффициент хэмжигч авто машинууд нь нислэг үйлдвэрлэлийн болон аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй байна. Мөн агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх авто машины шатахуун шахах хурд нь төслийн техникийн үзүүлэлтэд хүрэхгүй байна.	ЗТХЯ ИНЕГ ТХН	ЗТХЯ-ны агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Мягмарсүрэн АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Н.Энхбат	Мөстөлтийн эсрэг шингэн цацах авто машин, зурвасны үрэлтийн коэффициент хэмжигч авто машинуудыг шинээр солих, Агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх авто машины шатахуун шахах хурдыг төслийн техникийн үзүүлэлтийг

						бууруулахгүйгээр шинэчлүүлсэн байна.
1.7	Ангарын барилгыг барьж дуусгах	2018/06-2019/10	<p>Төслийн санхүүжилтийн үлдэгдэл хөрөнгөөр ангарын барилгыг барьж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар нийт санхүүжилтийн дүн 50 сая орчим ам доллар байна. /Энэхүү дүнд багтаан ангарын барилгыг оффиссын барилга болон бусад дагалдах иж бүрдлийн хамт барьж ашиглалтад өгөх/</p> <p>Одоогоор суурийн ажил, ангарын барилгын өмнөх зам талбайн ажлууд хийгдэж байна. Хуваарийн дагуу 2019 оны 4 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс "Санхүүжилт хүрэлцэхгүй байгаагаас иж бүрнээр нь ашиглалтад оруулахад хүндрэлтэй байна." гэсэн мэдээллийг өгч байна.</p> <p>2019 оны улсын төсөвт 10 тэрбум төгрөг суулгасан гэсэн мэдээлэлтэй байна. /Захиалагчийн зүгээс төслийн үлдэгдэл хөрөнгөнд багтааж ангарын барилгыг оффиссын барилга болон бусад дагалдах иж бүрдлийн хамт иж бүрэн барьж ашиглалтад өгөх, мөн зөвлөх үйлчилгээний зардал хэт өндөр байгааг бууруулах. Одоо барилгын ажлыг эхлүүлээд байгаа ангарын барилгын өртөг нь бусад агаарын тээвэрлэгчдийн ангар барих зардлын тооцооны саналуудаас хэт өндөр байгааг анхаарах/</p>	Сангийн яам ЗТХЯ ИНЕГ	<p>Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт</p> <p>ЗТХЯ-ны Агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Мягмарсүрэн</p> <p>Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Н.Энхбат</p> <p>АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн</p>	<p>Улаанбаатар хотын шинэ нисэх буудалд нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах шаардлагыг хангасан ангарын барилгатай болсноор дотоодын агаарын тээвэрлэгч компаниудын шинэ нисэх буудал руу нүүж ирэх гол шаардлага хангагдана.</p>
1.8	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын "Сонгино" талын эрчим хүчний эх үүсвэрийг холбох	10/01-11/01	<p>Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал нь эрчим хүчний нэг талын эх үүсвэрээр хангагдаж байгаа нь Иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангахгүй байна.</p> <p>/Сонгино талын эрчим хүчний эх үүсвэрийг барьсан гүйцэтгэгч тал /УБ хотын БУТ/ захиалгач тал /УБ хотын хөрөнгө</p>	ЭХЯ УБ хотын захиргаа	<p>ЭХЯ-ны сайд Ц.Даваасүрэн</p> <p>ЗТХ-ийн Дэд сайд Л.Халтар</p> <p>ЗТХЯ-ны Агаарын тээврийн бодлого зохицуулалтын</p>	<p>Иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй байдал хангагдана. Эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдана.</p>

			оруулалтын газар/ хоёрын хоорондын материал /2Ш трансфарматор/-ын үнийн зөрүүний талаарх шүүхийн маргаан нь шийдвэрлэгдэхгүй 2 жил болж байгаа нь шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах хугацаанд шууд нөлөөлж байна./		газрын дарга Д.Мягмарсүрэн АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн	
1.9	Сэргээгдэх эрчим хүчнээс гаргаж авсан нарны эрчим хүчийг төвийн шугам сүлжээнд ашиглах	10/01-12/01	Эрчим хүчний яам болон Эрчим хүчний зохицуулах газраас сэргээгдэх эрчим хүчнээс гаргаж авсан нарны эрчим хүчийг төвийн шугам сүлжээнд ашиглах асуудлыг тодорхой болгох. /сэргээгдэх эрчим хүчний тухай хууль/	ЭХЯ УБ хотын цахилгаан түгээх сүлжээ компани, Диспетчерийн үндэсний төв	Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын орчимд баригдаж байгаа сэргээгдэх эрчим хүчний байгууламжуудад төрөөс баримтлах бодлого тодорхой болно.
1.10	Морин уулан дахь нислэгийн цаг уурын станцын тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх	2019/02/01-04/01	Төсөвт суусан зардлын дагуу тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангаж эхлүүлэх	БОАЖЯ	Цаг уур орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин	Иргэний нисэхийн байгууллага болон Олон улсын шинэ нисэх буудлыг цаг уурын бодит мэдээллээр хангасан байна. Нислэгийн аюулгүй байдлын түвшин сайжирна.
2	<i>Төслийн ажлын даалгаварт тусгагдаагүй зайлшгүй хийх шаардлагатай ажлуудыг шийдвэрлэх. Үүнд:</i>					
2.1	Зорчигч терминалын дизель генераторын түлшний савны аюулгүйн бүсийг тогтоох, хашаа хамгаалалт хийх	10/01-12/01	Аюулгүй байдал хангагдаагүй байна.	ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Н.Энхбат	Аюулгүй байдал хангагдана.
2.2	Зорчигч терминалын барилгад В1 давхараас PIT давхарлуу буух	10/01-11/01	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдаагүй байна.	ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Н.Энхбат	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдана.

	хэсэгт шат угсрах					
3.	<i>Төслийн хөрөнгөөр хийгдсэн зарим шаардлага хангахгүй байгаа барилгын ажлуудыг шинэчлэн засварлах. Үүнд:</i>					
3.1	Зорчигч терминалын нийтийн эзэмшлийн 1 ба 2 давхарын гадна зам талбайд хийсэн явган замын хавтанг солих	10/01-11/01	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдаагүй байна.	ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Н.Энхбат	Улсын комиссоос өгөгдсөн даалгаврууд хангагдана. үүрэг
3.2	Зорчигч үйлилгээний барилгын 9 өрөөнд телефон холбоо, интернетийн сүлжээ, зарлан мэдээлэх систем суурилуулаагүй	10/01-11/01	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдаагүй байна.	ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Н.Энхбат	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдана.
3.3	Нислэгийн удирдлагын цамхагийн хяналтын өрөөнөөс зорчигч үйлчилгээний барилгын 1 ба 2-р хүзүүвч харагдахгүй байгаа	10/01-11/01	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдаагүй байна.	ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Н.Энхбат	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдана.
3.4	Бохир ус цэвэрлэх байгууламжийн удирдлагын системд алдаа зааж байгааг залруулах	10/01-11/01	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдаагүй байна.	ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Н.Энхбат	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдана.

3.5	Зорчигч терминалын барилгын ус зайлуулах системийн ажиллагааг бүрэн хангуулах	10/01-12/10	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдаагүй байна.	ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Н.Энхбат	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдана.
3.6	Үндсэн зээлийн хүрээнд баригдсан барилга байгууламжид улсын комиссоос өгөгдсөн нийт 1278 зөрчлийг арилгах ажлын явц <i>/Хавсралт 1/</i>	10/01-11/01	1278 зөрчил бүртгэгдсэнээс 1202 зөрчлийг залруулж, хаасан. 76 зөрчил үлдсэн. Түүнээс АӨЗ-нд шалгагдаж байгаа 6, зөрчлийг залруулах 12 ажил хийгдэж байна. Зөвлөх компанийн шийдвэрлэх 58 зөрчил үлдсэн байна. <i>/Нэмэлт зардлаар хийгдэх 58 зөрчил/</i>	ИНЕГ ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн дарга Н.Энхбат АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдана.
3.7	Үндсэн зээлийн хүрээнд ашиглалтын явцад гарсан 720 зөрчлийг арилгах ажлын явц <i>/Хавсралт 2/</i>	10/01-11/01	720 зөрчил бүртгэгдсэнээс 594 зөрчлийг залруулан хаасан. 126 зөрчил үлдсэн байна. Үүнээс төслийн зөвлөх компанийн шийдвэрлэх 100 зөрчил байна. <i>/Нэмэлт зардал шаардлагатай 83, баримт бичиг тайлбар хийж хаагдах 17 зөрчил/</i> Үлдсэн 26 зөрчлийг Ерөнхий туслан гүйцэтгэгч Самсунг компани залруулах ажил хийж байна.	ИНЕГ ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн дарга Н.Энхбат АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдана.
3.8	Нэмэл зээлийн хүрээнд баригдсан барилга байгууламжид улсын комиссоос өгөгдсөн нийт 689 зөрчлийг арилгах ажлын явц <i>/Хавсралт 3,4/</i>	10/01-11/01	689 зөрчил бүртгэгдсэнээс 505 зөрчлийг залруулан хаагдсан. 184 зөрчил үлдсэн. Зөвлөх компанитай холбогдох 39 зөрчил байна. Гүйцэтгэгч компанитай холбогдох 145 зөрчлийг залруулах ажил хийгдэж байна. Үндсэн томоохон зөрчлүүдийг залруулах ажил хийгдэж дууссан.	ИНЕГ ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн дарга Н.Энхбат АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн	Ашиглалт, засвар үйлчилгээний шаардлага хангагдана.
3.9	Төрийн хяналтын	10/01-2019/04/01	Газрын асуудал, барилгын зураг төсөв, техникийн нөхцөл, барилга барих	Сангийн яам ЗТХЯ,		Төвөөс алслагдсан төрийн хяналтын

	байгууллагуудыг ажиллах нөхцлөөр хангах, нэгдсэн оффиссын барилгын асуудлуудыг шийдвэрлэх		хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, төрийн хяналтын байгууллагуудын саналыг нэгтгэж, нэгдсэн барилга барих	ГЕГ, ХХЕГ, ГИХАЭГ, МХЕГ,	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор	байгууллагуудын ажиллах нөхцөл сайжирна.
Дөрөв. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:						
<i>УБ хотын шинэ нисэх буудалд олон улсын байгууллагуудаас болон дотоодын эрх бүхий байгууллагуудаас авах эрх, тусгай зөвшөөрөл, гэрчилгээ</i>						
4.1	Гаалийн баталгаат үйлдвэрийн тусгай зөвшөөрөл /Ангарын/	10/01-2019/04/01	Ангарын үйлчилгээ үзүүлэх байгууллага	ЗТХЯ, МИАТ, бусад агаарын тээвэрлэгч компаниуд	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн	УБ хотын Олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин бүрдэнэ.
4.2	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ	10/01-10/20	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний хугацаа дууссан.	ИНЕГ	АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн	Холбогдох хуулийн дагуу байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдсэн байна.
4.3	IATA-ийн газрын үйлчилгээний гэрчилгээ	10/01-2019/03/01	Шинэ нисэх буудал газрын үйлчилгээ хийсэн тохиолдолд	ИНЕГ ЗТХЯ	ЗТХЯ-ны Агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Мягмарсүрэн АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн	Шинэ нисэх буудалд газрын үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.
4.4	Эрчим хүчийг зохицуулалттай түгээх тусгай зөвшөөрөл	2019/01/01-03/01	Бусад тусгай зөвшөөрлүүдийг авсан. Эрчим хүчийг зохицуулалттай түгээх тусгай зөвшөөрлийг аваагүй байна.	ИНЕГ	АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн	Шинэ нисэх буудлаас бусад байгууллагуудад эрчим хүч түгээх эрх зүйн орчин бүрдэнэ.
4.5	Гаалийн баталгаат агуулахын тусгай зөвшөөрөл /1.Ачаа шуудан үйлчилгээ	2019/02/01-03/01	Төлөвлөлтийн хэмжээнд холбогдох материалыг бүрдүүлсэн. Оператор компаниас шалтгаалан ажил удаашралтай байна.	ГЕГ ИНЕГ	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт ИНЕГ-ын дарга Л.Бямбасүрэн	Ачаа шуудан үйлчилгээ үзүүлэх, зорчигчийн терминал, гаалийн хяналтын бүсэд үйлчилгээ

	2.Зорчигч терминал/				АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн	үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.
4.6	Шатахуун хангамжийн байгууламжийн тусгай зөвшөөрөл	2019/01/01-04/01	1.ИНД – 144 гэрчилгээ 2.Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах, агуулах, эзэмших 3.Гаалийн баталгаат агуулахын тусгай зөвшөөрөл 4.IATA олон улсын байгууллагын гэрчилгээ 5.Шатахуун бөөнөөр болон жижиглэнгээр худалдах тусгай зөвшөөрөл	ИНЕГ	ЗТХЯ-ны агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Мягмарсүрэн АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн Концесс эзэмшигч	Хөшигийн хөндийн Аэродромд Агаарын хөлгүүдийг сумлах эрх зүйн орчин бүрдэнэ.
4.7	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын Аэродромыг гэрчилгээжүүлэх	11/01-2019/02	ИНД-139-ийн шаардлагын дагуу гэрчилгээжих	ИНЕГ	ЗТХЯ-ны агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Мягмарсүрэн ИНЕГ-ын дарга Л.Бямбасүрэн АӨЗА-ны дэд дарга Н.Мягмарсүрэн	Хөшигийн хөндийн Аэродром нь нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй болно.
4.8	Шинэ нисэх буудалд Засгийн газрын тогтоолоор олгогдсон 2400 га газрын давхцлын асуудлыг шийдвэрлэх	10/01-11/20	Улсын тусгай хэрэгцээний газартай давхцалтай нийт 193 нэгж талбар байгаагаас: <ul style="list-style-type: none"> • 105 иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийг цуцлах (төсөл, сонгон шалгаруулалтгүйгээр газар авсан, газрын төлбөр төлөөгүй, сүүлийн 2 жилийн турш ашиглаагүй) • 4 иргэний газрыг нөхөн олговортойгоор эргүүлэн авах (зохих хуулийн дагуу байнгын үйл ажиллагаа явуулж байгаа) • 14 иргэний газрыг шилжүүлэх (зохих журмын дагуу бусдаас шилжүүлэн авсан) • 1 нэгж талбарыг үлдээх (ИНЕГ) • 2 нэгж талбарын асуудал тодорхойгүй байна. (нарны цахилгаан станц) 	ЗТХЯ, ИНЕГ, Төв аймгийн засаг дарга,	ЗТХ-ийн Дэд сайд Л.Халтар ЗТХЯ-ны Агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Мягмарсүрэн ИНЕГ-ын дарга Л.Бямбасүрэн Төв аймгийн засаг дарга Ж.Батжаргал	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын газар эзэмших асуудалтай холбоотой зөрчлийг арилгасан байна.


			Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын газартай нийт 14 нэгж талбар давхцалтай.			
4.9	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал дээрх агаарын боомтын асуудлыг шийдвэрлэх		Холбогдох байгууллагуудын бэлтгэл ажил хангагдаагүй байна.	ЗТХЯ, ГЕГ, ГИХАЭГ, МХЕГ	ЗТХ-ийн Дэд сайд Л.Халтар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт ИНЕГ-ын дарга Л.Бямбасүрэн	Агаарын боомт байгуулах засгийн газрын тогтоол гарсан байна. Түүний нэр, үйл ажиллагаатай холбоотой бэлтгэл ажлуудыг эхлүүлэх
4.10	УБ хотын олон улсын шинэ нисэх буудлын ерөнхий төлөвлөлтийг шинэчлэн батлуулах	10/01-10/15	Төсөл эхлэх үед ЗТХЯ-аас баталсан ерөнхий төлөвлөлт нь өнөөгийн шаардлагыг хангахгүй байна.	ЗТХЯ, ИНЕГ	ЗТХЯ-ны Агаарын тээврийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн ИНЕГ-ын дарга Л.Бямбасүрэн АӨЗА-ны дэд Н.Мягмарсүрэн	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эхлэхтэй холбогдуулан ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, шинэчлэн батлуулсан байна.
4.11	Дагуул хотын төлөвлөлтийг шинэ нисэх буудлын төлөвлөлттэй уялдуулах	10/01-12/01	Барилга, хот байгуулалтын яамнаас боловсруулсан дагуул хотын шинэчилсэн төлөвлөлт нь шинэ нисэх буудлын үйл ажиллагаатай хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй байна.	ЗТХЯ, БХБЯ, Төв аймгийн ЗДТГ	БХБ-ын сайд Х.Баделхан Төв аймгийн засаг дарга Ж.Батжаргал ЗТХЯ-ны агаарын тээврийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн	Барилга, хот байгуулалтын яамнаас боловсруулсан дагуул хотын шинэчилсэн төлөвлөлт нь шинэ нисэх буудлын үйл ажиллагаатай харилцан уялдаа тодорхой болсон байна.
4.12	УБ хотын ОУШНБ-ын Хурдны зам олон улсын стандартыг хангаж байгаа	2018/10/01-2019/03/15	Хурдны замын гэрэлтүүлэг бусад стандарт үзүүлэлтүүд тодорхой бус байна.	ЗТХЯ	ЗТХЯ-ны агаарын тээврийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн	Олон улсын хурдны авто замын стандарт шаардлагыг хангуулсан байна.

	эсэхийг нягтлах, тухайн өртөгт багтаагүй асуудлуудыг шийдвэрлэх				ЗТХЯ-ны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Доржханд	
4.13	УБ хотын ОУШНБ-ын хурдны замын үйл ажиллагааг эрхлэн явуулах компанийн асуудлыг шийдвэрлэх	2018/10/01-2109/02/01	Хурдны замын үйл ажиллагааг эрхлэн явуулах компани нь өнөөдрийг хүртэл тодорхой бус байна.	ЗТХЯ, ТӨБЗГ	ТӨБЗГ-ын дарга Ц.Ням-Осор ЗТХЯ-ны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Доржханд	Хурдны замын үйл ажиллагааг эрхлэн явуулах компанийг тодорхой болгосон байна. Шинэ нисэх буудалтай хамтран ажиллах, төлөвлөх, нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай уялдуулах ажил шийдвэрлэгдэнэ.
4.14	УБ хотын ОУШНБ-ын нийтийн тээврийн асуудлыг шийдвэрлэх	2018/10/01-2019/03/01	Зорчигч, үйлчлүүлэгчдэд зориулсан нийтийн тээврийн асуудал тодорхойгүй байна. Хотын нийтийн тээврийн газар дээр байгуулагдсан ажлын хэсгээс тодорхой үр дүн гараагүй байна.	ЗТХЯ, УБ хотын захиргаа, УБ хотын нийтийн тээврийн газар	ЗТХЯ-ны Агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Мягмарсүрэн Нийслэлийн дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийг хариуцсан орлогч дарга П.Баярхүү	Зорчигч, үйлчлүүлэгчдэд зориулсан нийтийн тээврийн асуудал шийдвэрлэгдсэн байна.
4.15	Буянт-Ухаа дахь "Чингис хаан" олон улсын нисэх буудлын зориулалт, ашиглалт, өмчлөл, ангилал, зэрэглэл, стандартын шаардлагыг хэвээр хадгалах,	2018/10/01-2018/11/01	Буянт-Ухаа дахь "Чингис хаан" олон улсын нисэх буудлын цаашдын ашиглалтын талаар тодорхой шийдвэр гараагүй байна.	ЗТХЯ, ИНЕГ	ЗТХЯ-ны Агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Мягмарсүрэн ИНЕГ-ын дарга Л.Бямбасүрэн	Буянт-Ухаа дахь "Чингис хаан" олон улсын нисэх буудлын цаашдын ашиглалтын талаар Засгийн газрын тогтоол, шийдвэр гарсан байна.

	цаашдын үр өгөөжийг сайжруулахтай холбогдсон Засгийн газрын тогтоол шийдвэр гаргуулах					
--	---	--	--	--	--	--

ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ДЭД САЙД




Л.ХАЛТАР

БОЛОВСРУУЛСАН: ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ

АГААРЫН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ХЭЛТСИЙН ДАРГЫН

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МЯГМАРСҮРЭН